

**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Инновэйшн Инвестмент” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсугай:

1.1. Б.Анар /РД:	г - ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
1.2. Х.Доржсүрэн /РД:	г - ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
1.3. Г.Саран /РД:	г - ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
1.4. Н.Тэмүүжин /РД:	г - ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
1.5. У.Наранбаатар /РД:	г - ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
1.6. Б.Чулуунсүх /РД:	г - ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
1.7. Х.Болдсүх /РД:	г - ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
1.8. М.Болод /РД:	г - ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
1.9. Г.Энхмаа /РД:	г - ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж болон улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Энхболд/-д үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөл томилогдсонтой холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаа сонгох, компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд үр ашигтай бөгөөд зохистойгоор удирдан явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



А.БАТТАМИР